



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 127
дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 11,626,065.0 (арван нэгэн сая зургаан зуун хорин зургаан мянга жаран тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 127 дугаар сургууль (С.Хүрэлбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 4 нэр төрлийн 11,626,065.0 (арван нэгэн сая зургаан хорин зургаан мянга жаран тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 127 дугаар сургууль (С.Хүрэлбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *Т.Оюунтуул* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 08 дүгээр сарын 09...-ны өдрийн 1/03 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: 127-р сургууль

д/д	Хөрөнгийн нэр	Ашигла сан жил	Тоо хэмжээ	Нэг бүрийн балансын үнэ	Балансын нийт үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХТ-ийн мэргэжилтний үнийн санал	ЭБХХК-ын хурлын шийдвэр
1	Суурин компьютер	5	5	1,571,613.00	7,858,065.00	7,858,065.00	0.00	ашиглалтын шаардлага хангахгүй	актлах	устгах	татах	татах
2	Иж бүрэн камер	5	16	198,000.00	3,168,000.00	3,168,000.00	0.00		актлах	устгах	татах	татах
3	Өнгөт принтер	5	1	370,000.00	370,000.00	370,000.00	0.00		актлах	устгах	татах	татах
4	Ус буцалгагч	5	1	115,000.00	115,000.00	115,000.00	0.00		актлах	устгах	татах	татах
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				23	11,511,065.00	11,511,065.00						
Үүнээс: Худалдах хөрөнгө												
Устгах хөрөнгө												
Татан төвлөрүүлэх хөрөнгө					11,626,065.00							